



АВЛИГЫН ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв ТББ-д “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр цацагдсан авлигын шинжтэй гэмт хэргийн шийдвэрлэлт” сэдвийн хүрээнд мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Тус мониторингийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн сүлжээгээр нийтэд цацагдсан авлигын шинжтэй гэмт хэргийн шийдвэрлэлтэд мониторинг хийж, үр дүнг олон нийтэд мэдээлэхийг зорилоо.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг www.forum.mn сайтаас үзнэ үү.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АТГ	Авлигатай тэмцэх газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТВ	Телевиз
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

АРГА ЗҮЙ

Мониторингийн хүрээнд олон нийтэд нээлттэй тоон мэдээлэл, салбарын хүрээнд хийгдсэн судалгааны тайлан, мэдээллийг судлан анализ хийлээ.

Бүдүүвч 1. Мониторингийн аргачлал



Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийн шийдвэрлэлтийг судлахдаа сүүлийн 3 жилд авлигын шинж чанартай, иргэд, олон нийтэд мэдээлэгдсэн 72 хэрэг бүхий мэдээллийн сан үүсгэсэн болно. Ингэхдээ эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл¹ буюу авлигын

гэмт хэрэгт хамаарах хэргийн мэдээллийг шүүв. Мөн өдөр тутмын 5 сонин болон вэб сайтаар сүүлийн 3 жилд мэдээлэгдсэн авлигатай холбоотой гэмт хэргийн мэдээллийг нэг бүрчлэн шүүж холбогдогч

болон хэргийн шийдвэрлэлтийн байдлыг судаллаа. Мэдээллийн эх сурвалжийн хувьд ихэвчлэн АТГ-ын мэдээлэлд үндэслэсэн ч зарим тохиолдолд УЕПГ, Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээлэлд үндэслэсэв.


МОНИТОРИНГИЙН ДҮН

1.1. Олон нийтэд мэдээлэгдсэн авлигын хэргийн шийдвэрлэлт

Сүүлийн 3 жилийн хугацаанд олон нийтэд мэдээлэгдсэн авлигын шинжтэй 72 хэргийн 18 тохиолдлын холбогдогч этгээд нь улс төрийн өндөр албан тушаалтан байна. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн болон гишүүн асан,

сайд болон төрийн өндөр албан тушаалтан байв. Түүнчлэн иргэд, олон нийтэд мэдээлэгдсэн хэргүүд нь мэдээллийн сайт, өдөр тутмын бүх сониноор 1-152 удаагийн давтамжтай мэдээлэгджээ. Мэдээллийн дийлэнх эх сурвалж АТГ-ын мэдээлэл байлаа.

График 1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал



Олон нийтэд мэдээлэгдсэн авлигын шинжтэй 72 гэмт хэргийн шийдвэрлэлтийг авч үзэхэд 25 нь шалгагдаж байгаа, 29 хэргийн шийдвэрлэлтийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч чадаагүй байгаа, 12 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж холбогдох хүмүүс ял авсан, 3 хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон, мөн прокурорын шатанд 3 хэрэг хэрэгсэхгүй болсон байдалтай байна.

Мэдээлэл тодорхой бус, хэргийн шийдвэрлэлтийн мэдээллийг холбогдох байгууллагаас авч чадаагүй байгаа 29

хэргийн хоёрынх нь холбогдогч олны танил хүмүүс буюу БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга, УИХ-ын гишүүн асан Г.Нямдаваа, Шадар сайд асан Ц.Оюунбаатар нар байлаа. Шалгагдаж буй 25 хэргийн 18 нь олны танил эзэн холбогдогчтой байсан бөгөөд давхардсан тоогоор ерөнхий сайд 4, салбарын сайд 5, УИХ-ын гишүүн 4, төрийн байгууллагын удирдах албан тушаалтан 6 байв.

Нийт 72 хэргээс шүүхээр шийтгэгдэж ял, шийтгэл авсан 12 хэрэг байгаа бөгөөд

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 оны 12 дугаар сарын 3, <https://www.legalinfo.mn/law/details/11634>

үүний 5 хэргийн холбогдогчдыг хорих ялаар шийтгэж, үлдсэн 7 хэрэгт торгуулийн болон нийтийн албанд ажиллах эрхийг хасах шийтгэл оногдуулжээ. Эдгээр 12 хэргийг шүүхээр шийдвэрлэх явцад 1 тэрбум 815 сая төгрөгийг улсын орлого болгож, 193.8 сая төгрөгийн торгууль оногдуулж, 11 хүний нийтийн албанд ажиллах эрхийг 3 жилээр тус тус хасжээ. Энэ дунд “60 тэрбумын” гэгдэх хэрэгт холбогдсон Ц.Сандуй, А.Ганбаатар нарт тус бүр 4 жилийн хорих ял оноосон ч Нийслэлийн давж заалдах шатны шүүх 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр анхан шатны шүүхээс оноосон ялыг хүчингүйд тооцож, уг хэргийг прокурорт буцаасан байна. Хорих ялаар шийтгэгдсэн бусад ялтан шийтгэлээ эдэлж байна.


Шүүхээр ял шийтгэгдсэн эдгээр 12 хэргийн шийдвэр шүүхийн цахим санд байгаа эсэхийг хянаж үзэхэд зөвхөн ерөнхий боловсролын 1-р дунд сургуулийн захирал Г.Бум-Эрдэнэд холбогдох “нэгдүгээр ангид хүүхэд элсүүлж авах болон дунд ангид өөр сургуулиас хүүхэд шилжүүлэн авахдаа бусдаас хахууль авдаг байсан” гэх хэргийн шийдвэр байршсан байсан бөгөөд бусад хэргийн мэдээлэл

байхгүй байлаа. Тухайн албан тушаалтанд 12 сая төгрөгийн торгуулийн ял оноожээ.

Нийт мэдээлэгдсэн хэргийн 35.6 хувь буюу 26 тохиолдолд холбогдогч этгээд нь төрийн өндөр албан тушаал хашдаг бөгөөд олны танил хүн байв. Тодруулбал, давхардсан тоогоор Монгол Улсын Ерөнхий сайд асан 4, салбарын сайд 8, УИХ-ын гишүүн болон гишүүн асан 18, төрийн өндөр албан тушаалтан 24 хүн холбогджээ. Эдгээр 26 тохиолдлын 1 нь хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй, 17 нь шалгагдаж байгаа, 3 нь шүүхээр шийдвэрлэгдэж ял авсан, 2 нь прокурорын шатанд хэрэгсэхгүй болсон, 3 нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан шалтгаанаар хэрэгсэхгүй болжээ.

Хэрэгсэхгүй болсон дээрх 6 хэргээс Зэвсэгт хүчний жанжин штабын Хуурай замын цэргийн командлалын хэлтсийн дарга хурандаа Ц.Жавхланбаатар, МИАТ-ийн дэд захирал Х.Энхбаатар, Зам тээврийн яамны газрын даргаар ажиллаж байсан Р.Онон, ЗГХЭГ-ийн дарга асан Г.Дэнзэн, УИХ-ын гишүүн асан Н.Батбаяр, Б.Гарамгайбаатар нарын 5 хэргийг хэрэгсэхгүй болгон

График 2. Шударга байдлын үнэлгээний үр дүн, Монгол Улсад авлига их тархсан институцийн төсөөлөл



шийдвэрлэсэн бол Салхитын мөнгөний ордын эзэмшигч нартай холбоотой хэргээр шалгагдаж байхдаа амь насаа алдсан шүүгч агсан Л.Бямбаагийн хэргийг хааж, бусад оролцогчийн хэргийг тусгаарлан шалгаж байгаа ажээ.


Хөөн хэлэлцэх хугацаа дууссан 3 хэргийн хувьд олон нийт ихээхэн шүүмжлэлтэй хандаж, шүүхийн үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа нь ажиглагдсан. Тухайлбал, УИХ-ын гишүүн асан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр болон УИХ-ын гишүүн асан Б.Гарамгайбаатар нарт холбогдох хэргийг 2018 оны 9 дүгээр сард шүүхэд шилжүүлэх саналтай илгээсэн ч хэрэг удааширсаар хөөн хэлэлцэх хугацаа нь дуусаж, хэрэгсэхгүй болсон байна. Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр УЕПГ уг хэргийг сэргээн шалгах

шийдвэр гаргажээ. Улмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар АТГ-т 2020 оны 4 дүгээр сарын эхээр шилжүүлсэн байна.

АТГ-аас хийдэг “Шударга байдлын үнэлгээ” судалгаа нь манай улсад авлига хэр тархсан талаарх иргэдийн төсөөллийг судалдаг бөгөөд тус судалгааны үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэгдсэн авлигын хэргийн талаарх мэдээлэлтэй харьцуулсныг График 2-оос харна уу.

АТГ-ын “Шударга байдлын үнэлгээ” судалгаагаар шүүх, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагад авлига хамгийн их тархсан гэж иргэд үзжээ. Гэвч сүүлийн 3 жилд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын хэргийн 45.8 хувийг яам, агентлагийн хүрээнд гарсан авлигын хэргийн талаарх мэдээлэл эзэлж байна (График 3-ыг харна уу).


График 3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр



Харин нийтэд мэдээлэгдсэн авлигын гэмт хэргийн холбогдогчийг байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, хамгийн олон тохиолдол нь салбарын яамдын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны холбогдсон хэргүүд байлаа. Тухайлбал, нийт мэдээлэгдсэн хэргийн 30.6 хувьд салбарын яамдын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан

холбогджээ. Түүнчлэн нийтэд мэдээлэгдсэн хэргийн 18.1 хувийг Засгийн газрын гишүүд холбогдсон гэмт хэрэг эзэлж байгаа нь улс төрийн албан тушаалтан авлигын гэмт хэрэгт холбогдож байгаа талаарх мэдээллийг олон нийт мэдэх сонирхол өндөр байдагтай холбон тайлбарлаж болох юм.

График 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийн тоо, албан тушаалын ангиллаар



Нийтэд мэдээлэгдсэн авлигын гэмт хэргийг холбогдогчийн албан тушаалын ангиллаар нь авч үзвэл 30.6 хувь буюу 22 хэрэгт төрийн

захиргааны албан тушаалтан, 25.0 хувь буюу 18 хэрэгт улс төрийн албан тушаалтан холбогджээ.

Хүснэгт 1. Хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлэгдсэн авлигын шинжтэй хэргийн шийдвэрлэлт, холбогдогчийн албан тушаалын ангиллаар

Хэргийг шийдвэрлэсэн байдал	Төрийн захиргааны албан тушаалтан	Төрийн тусгай албан тушаалтан	Төрийн үйлчилгээний албан тушаалтан	Улс төрийн албан тушаалтан
Тодорхойгүй	11	14	7	3
Хөөн хэлэлцэх хугацаа дууссан	2	0	1	1
Шалгагдаж байгаа	7	3	3	13
Шүүхээр шийтгэгдэж хуулийн дагуу ял авсан	2	1	2	1
Нийт	22	18	13	18

Олон нийтэд мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судлахад төрийн захиргааны албан тушаалтан холбогдсон хэргийн 50.0 хувь, төрийн тусгай албан хаагч холбогдсон хэргийн 77.0 хувь, төрийн үйлчилгээний албан тушаалтан холбогдсон хэргийн 53.0 хувь, улс төрийн албан тушаалтан холбогдсон хэргийн 16.0 хувь хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, нийт мэдээлэгдсэн авлигын шинжтэй гэмт хэргийн 50.0 орчим хувь тодорхой биш байдлаар ахин мэдээлэгдэхгүй, хэрхэн шийдсэн талаарх мэдээллийг хуулийн байгууллагаас тодруулах боломжгүй байлаа.

Бид сүүлийн 3 жил олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн авлигын шинжтэй дээрх хэргүүдийн мэдээллийг шүүхийн цахим санд байршсан, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдтэй харьцуулж судалсан юм. Судалгааны үр дүнд шүүхийн цахим санд байгаа шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн эсэх нь тодорхой бус, мөн хэрэгт холбогдогч нь олны танил, улс төрийн болон төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтан болохыг тодорхойлсон тохиолдол ховор байлаа. Эндээс дүгнэхэд, авлигын шинж чанартай гэмт хэргийн шийдвэрлэлтийг олон нийтэд мэдээлэх үйл явц хангалтгүй байна гэж үзлээ.

Олон нийтэд мэдээлэгдсэн анхаарал татсан хэргүүдийг хэд хэдэн эх сурвалжид өөр өөр байдлаар нийтлэх, хүргэх тохиолдол гарчээ. Тухайлбал, 2017 онд шуугиан тарьсан, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын гаалийн байцаагч нарын удаа дараагийн авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг дурдаж болно. Тус хэргийн талаар “Өдрийн

сонин”-д нийтлэхдээ эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолын хэрэгт холбогдогчдод оногдуулсан ял, шийтгэлийн талаар үнэн бодит мэдээлэл бичсэн ч хэрэгт холбогдогчийн тоог олон нийтэд буруу мэдээлсэн байна.² Тус эрүүгийн хэрэгт нийт 34 хүн холбогджээ.

Дорноговийн Замын-Үүдийн боомт өнөө цагийн хамгийн том авлигын үүр гэгдэх болсон. Үүний тод жишээ бол саяхан шийдэгдсэн гаалийн байцаагч нар 36 хүнд холбогдох хэрэг юм. Хэргийг сөхвөл Замын-Үүдийн гаалийн Зөрчлийн албаны дарга асан Цэен, Гааль татварын ерөнхий газрын Бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалтын газрын дарга Мөнхчулуун, Замын-Үүдийн Хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Оюунчимэг нарын 7-8 байцаагч бусдаас хахууль авсан нь шалгалтын үеэр илэрсэн байдаг. Зөвхөн эдгээр байцаагчаар зогсохгүй байцаагч нарт хахууль өгсөн, зуучилсан гэх нийтдээ 36 эзэн холбогдогчтой томоохон авлигын хэрэг жил дамнан хууль шүүхийн байгууллагад хэлэлцэгдэж байгаа. Дээрх байцаагчид гаалийн бүрдүүлэлт хийсэн авто машинуудад хяналт шалгалтыг зохих ёсны дагуу хийдэггүй, БНХАУ-аас Замын-Үүд дэх гаалиар орж ирсэн машинуудаас ачааны татварын мөнгийг хуулийн дагуу авдаггүй, жолооч нартай тохиролцож өөрсдөө татварын мөнгийг халаасалдаг болохыг илрүүлсэн билээ. Ингэхдээ найман байцаагчид 1-6, бусдад нь нэг жил зургаан сарын тэнсэн харгалзах ял оноосон билээ. Найман байцаагчаас тус бүр 1-3 сая хүртэлх төгрөгийн хөрөнгө хурааж авсан байдаг. Тэгвэл тухайн үед дээрх байцаагчид өдөрт 50-100 сая төгрөгийг улсад оруулах бус өөрсдөө халаасалдаг байсан талаар мэдээлэл цацагдаж байсан. Ингээд бодохоор хэдэн зуун саяар нь идсэн байцаагчид ганц хоёрхон жилийн ял авчхаад улсад учруулсан хохирлоо барагдуулсан мэт харагдаад үлддэг. Харин цаана ганц хоёроор тогтохгүй байр, үнэтэй машин гээд насныхаа хөрөнгийг хураасан байдаг талаар яриа бий. Энэ ч үнэний ортой болов уу. Учир нь Замын-Үүдийн гаальд хэлтэс, албаны даргын албан тушаалд очихын тулд 20-30 сая төгрөг, ахлах байцаагч болохын тулд 10-15 сая төгрөгийн хахууль өгдөг бол байцаагчаар очихын тулд багадаа таван сая төгрөгийн хахууль өгдөг болохыг гаалийнхан хоорондоо ярьдаг гэнэ.

Өдрийн сонин, 2017.07.03

Харин уг хэргийн талаар ikon.mn сайт мэдээлэхдээ уг хэрэгт 34 гаалийн байцаагч холбогдсон мэтээр мэдээлжээ. Үнэн хэрэгтээ 8 гаалийн байцаагч, хахууль өгсөн 26 этгээд уг хэрэгт холбогдсон юм. Мөн уг хэргийн оролцогчдод бүгдэд нь 2-6 жилийн ял өгсөн мэтээр бичжээ.

Зөвхөн дээр дурдсан хоёр жишээнээс үзэхэд мэдээллийн зөрүүтэй байдал ажиглагдаж байна. Энэ нь иргэд, олон нийтэд хэргийн учир байдлыг үнэн зөв ойлгоход бэрхшээл болох нэг нөхцөл юм. Тиймээс мэдээллийн эх сурвалжийг баталгаатай байлгаж, эрэн сурвалжлах, хэргийн мөрөөр ажилласан мэдээ, мэдээллийг иргэдэд бодитой хүргэх нь зүйтэй.

Зураг 1. Хэвлэлийн мэдээлэл, ikon.mn



АТГ-аас өнөөдөр хийсэн хэвлэлийн хурлын үеэрээ нэгэн бичлэгийг олон нийтэд харуулсан юм. Уг бичлэгт Замын-Үүд дэх гаалийн газрын ажилтнуудын нуусан мөнгийг АТГ-ын ажилтнууд баримтжуулан авч байгааг харуулсан байна.

2015-2016 онд Замын-Үүд дэх Гаалийн газрын 34 ажилтан холбогдсон хээл хахуулийн хэргийг АТГ-аас илрүүлэн юм. Уг хэрэг 2018 оны нэгдүгээр сард шүүхээр шийдэгдэн, 34 гаалийн ажилтанд 2-6 жилийн ял оноосон билээ.

Хэргийг илрүүлэн нэгжлэн хийх явцад гаалийн байцаагч нар бусдаас хахуульд авсан бэлэн мөнгөө нуун далдлах зорилгоор агааржуулалтын хоолой, тавилга зэргийн араар нуусан байсныг харуулсан байна.

Эх сурвалж: ikon.mn

² <https://dnn.mn/>

Судалгааны тайланг боловсруулж байх үед АТГ-ын мэдээлснээр 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар 73 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлжээ. Эдгээр хэргийн дийлэнх нь олны анхаарал татсан, улс төрийн албан тушаалтан холбогдсон хэргүүд байлаа.³ Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатад холбогдох хэрэг;
- Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Солтан, Д.Дамба-Очир нарт холбогдох хэрэг;
- Монгол Улсын Их Хурлын гишүүн асан Н.Номтойбаярт холбогдох хэрэг;
- Монгол Улсын сайдаар ажиллаж байсан М.Энхсайханд холбогдох хэрэг;
- Эрүүл мэнд, спортын сайдын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Ц.Оюунбаатар, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн даргаар ажиллаж байсан Д.Жаргалсайхан нарт холбогдох хэрэг;
- Монгол Улсын Засгийн газар, “Айванхоу Майнз Монголия Инк” ХХК, “Айванхоу Майнз Лимитед”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед” компанийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үйл явцад холбогдох хэрэг;
- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч даргаар ажиллаж байсан Д.Ариунбаатарт холбогдох хэрэг;
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн мэргэжилтнүүдэд холбогдох хэрэг;
- Нэр бүхий шүүгч нарт холбогдох хэрэг;

- Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Гаалийн газрын улсын ахлах байцаагч Я.Очирбатад холбогдох хэрэг;
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 49 хувь, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авсантай холбогдох хэрэг;
- “Жаст групп” ХХК-ийн захирал Ш.Батхүү нарт холбогдох хэрэг;
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирлаар ажиллаж байсан Ц.Даваацэрэн нарт холбогдох хэрэг;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан Ч.Алтанхуягт холбогдох хэрэг;
- Зам тээврийн хөгжлийн сайд асан Д.Ганбат, Зам тээврийн хөгжлийн яамны газрын дарга Д.Доржханд нарт холбогдох хэрэг.

Гэтэл шүүхэд шилжүүлсэн гэх жагсаалтад орсон зарим хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл өмнө нь мэдээлэгдэж байсан байна. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягийн албан тушаалаа урвуулан ашиглаж бусдад давуу тал бий болгосон талаарх хэргийг шийдвэрлэсэн тухай мэдээлэл 2020 оны 3 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд олон нийтэд мэдээлэгджээ.

Тус мэдээллээр Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын дарга Ч.Алтанхуяг, “Чингис хаан” банкны гүйцэтгэх захирал С.Сандагдорж нарт холбогдох хэргийг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Баасан гарагт (2020.03.27) хялбаршуулсан журмаар хэлэлцэн шийдвэрлэж торгуулийн ял оноосон гэжээ.

³ Өдрийн сонин. <https://dnn.mn/> 2020.04.29 10:04 АТГ-аас 73 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлэв.

Зураг 2. Хэвлэлийн мэдээлэл, news.mn⁴

news.mn
ЭМДЕГААС МӨНГӨ УГААСАН АЛБАН ТУШААЛТНУУДЫГ ТОРГОЖЭЭ

f
t
+

ЭМДЕГ-аас мөнгө угаасан албан тушаалтнуудыг торгожээ

N

NEWS.MN
 НИЙГЭМ / ХУУЛЬ, ШҮҮХ / © 2020-03-29

f ХУВААЛЦАХ
t ЖИРГЭХ
+



Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын /ЭМДЕГ/ дарга Ч.Алтанхуяг, “Чингис хаан” банк болон тус банкны гүйцэтгэх захирал С.Сандагдорж нарт холбогдох хэргийг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Баасан гаригт /2020.03.27/ хялбаршуулсан журмаар хэлэлцэн шийдвэрлэжээ.

Хэргийн холбогдогч нар хэргээ шуурхай шийдвэрлүүлэх хүсэлт нийслэлийн прокурорын гаргасныг прокурор хүлээн авч, яллах дүгнэлт үйлдэн дээрх шүүхэд шилжүүлсэн нь энэ юм.

Тэгвэл Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс “Чингис хаан” банк, тус банкны гүйцэтгэх захирал С.Сандагдорж, ЭМДЕГ-ын дарга Ч.Алтанхуяг нарыг хээл хахууль өгч, авсан гэм буруутайд тооцжээ.

Улмаар Эрүүл мэндийн болон Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг тус банканд байршуулах эрхийг гурван жилээр хасч, Гүйцэтгэх захирал С.Сандагдоржийг төрийн албанд ажиллах эрхийг хоёр жил хасч, долоон сая, ЭМДЕГ-ын дарга Ч.Алтанхуягийг мөн хугацаагаар төрд ажиллах эрхийг нь хязгаарлаж, 30 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн байна.

ШИНЭ МЭДЭЭ

- Т.Ариунтуяа: Бодлоо зөв болгосон хүн хуримтлалтай болдог
🕒 8 минутын өмнө
- Н.Номтойбаяр нэр дэвших боллоо хангажээ
🕒 12 минутын өмнө
- Японы эзэн хааны ордон руу сэлж нэвтрэхийг завджээ
🕒 20 минутын өмнө
- Конорын дараагийн өрсөлдөгч Камару Усман уу?
🕒 34 минутын өмнө
- Баян-Өлгий: МАҮ, АН шинэ залуучууд сойж байна
🕒 40 минутын өмнө
- Хятадаас Ангараг гариг руу робот илгээнэ
🕒 43 минутын өмнө
- Путин Кремлийн ордонд эргэн иржээ
🕒 50 минутын өмнө

ШИНЭ МЭДЭЭ

Т.Ариунтуяа: Бодлоо зөв болгосон хүн хуримтлалтай болдог
🕒 8 минутын өмнө

Н.Номтойбаяр нэр дэвших боллоо хангажээ
🕒 12 минутын өмнө

Японы эзэн хааны ордон руу сэлж нэвтрэхийг завджээ
🕒 20 минутын өмнө

Конорын дараагийн өрсөлдөгч Камару Усман уу?
🕒 34 минутын өмнө

Баян-Өлгий: МАҮ, АН шинэ залуучууд сойж байна
🕒 40 минутын өмнө

Хятадаас Ангараг гариг руу робот илгээнэ
🕒 43 минутын өмнө

Путин Кремлийн ордонд эргэн иржээ
🕒 50 минутын өмнө

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр голдуу олны танил, улс төрийн албан тушаалтан холбогдсон авлигын хэргийг мэдээлдэг хэдий ч хэргийн шийдвэрлэлт тодорхойгүй, шийдвэрлэгдэхгүй уддаг, улмаар хэрэгсэхгүй болдог гэх хардлага олон нийтийн дунд байсаар байна. Тухайлбал, шүүхэд

шилжүүлсэн хэрэг шүүхийн шатанд хэрхэн шийдэгдэхийг олон нийт анхааралтай ажиглаж байгаа нь мэдээний сэтгэгдэл хэсгээс харагдаж байна. Мөн авлигын хэргийг шударгаар шийдэж байгаа эсэхэд олон нийт ихээхэн эргэлздэг болох нь судалгааны явцад ажиглагдсан.


⁴ <https://news.mn/r/2279968/>

1.2. Авлигын гэмт хэргийн талаарх албан ёсны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Энэхүү мониторингийн хүрээнд Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны албан ёсны мэдээллийн сайт⁵, АТГ-ын мэдээллийн сайтад⁶ буй авлигын гэмт хэргийн статистик тоон мэдээлэл болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн 2009-2017 оны авлигын хэргийн шийдвэрлэлтийн талаарх статистик мэдээлэл, шүүхийн цахим санд⁷ буй 2017 оноос хойших авлигын хэргийн шүүхийн шийдвэрлэлтийн мэдээлэлд шинжилгээ хийлээ. Гэмт хэргийн талаар хуулийн байгууллагууд өөрийн мэдээллийн сайтаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэж байгаа ч тэдгээр нь хоорондоо зөрүүтэй байх тул ҮСХ болон АТГ-ын мэдээллийн сайт дахь тоон мэдээллийг авч ашиглалаа.

2019 онд улсын хэмжээнд 31,524⁸ гэмт хэрэг бүртгэгдсэнээс 1.7 хувь буюу 523 нь авлигын гэмт хэрэг байна. 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 162.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан бол авлигын гэмт хэргийн улмаас 12.1⁹ их наяд төгрөгийн хохирол учирсан талаар ҮСХ, АТГ-ын тайланд дурдагджээ. Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос 74 дахин их үзүүлэлт юм. Авлигын гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувь бага ч учруулж буй хохирлын хэмжээ асар их болохыг дээрх тоо, мэдээ харуулж байна. Үүний зэрэгцээ авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын дүн мэдээнд оруулдаггүй гэж ойлгохоор байна.

График 5. Бүртгэгдсэн авлигын гэмт хэрэг



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

ҮСХ-ны мэдээнээс авлигын гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн нь харагдаж байна. Тухайлбал, 2012-2017 онд 100-150 орчим авлигын гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол зөвхөн 2019 онд 523 хэрэг бүртгэгдсэн байгаа нь 2017 оны үзүүлэлтээс 3.4 дахин нэмэгджээ. Энэ нь гэмт хэргийн гаралт нэмэгдсэн гэхээс илүүтэй илрүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой байж

болох юм. Мөн түүнчлэн иргэдийн гомдол, мэдээлэл тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа нь тодорхой. АТГ-ын мөрдөн шалгах ажиллагааны тайлан мэдээгээр 2016 оны 6 дугаар сараас 2019 оны эцэс хүртэлх хугацаанд ирүүлсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн байдлыг График 6-д харууллаа.

⁵ www.1212.mn

⁶ <https://www.iaac.mn/>


⁶ <http://www.shuukh.mn/>

⁷ www.1212.mn ҮСХ

⁸ АТГ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан www.iaac.mn

⁹ АТГ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлан www.iaac.mn

График 6. АТГ-т ирүүлсэн авлигын гэмт хэргийн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн мэдээлэл




Эх сурвалж: АТГ, www.IAAC.mn

Дээрх графикаас харахад АТГ-т иргэд, холбогдох байгууллагаас ирүүлж буй гомдол, мэдээлэл жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгааг харж болно. Нэн ялангуяа 2017 оны 3-р улиралд нэлээдгүй хэмжээгээр өсжээ.

Авлигын гэмт хэргийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтэд ахиц гарч байгаа ч хэргийн шийдвэрлэлтэд анхаарах нь чухал.

График 7. Авлигын хэргийн шийдвэрлэлтийн мэдээ, 2018 он



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

ҮСХ-ны мэдээгээр 2018 онд 1,138 авлигын хэрэг шалгаж шийдвэрлэснээс 4-ийг хэрэгсэхгүй болгож, 466 хэргийг

яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорын байгууллагад шилжүүлсэн бол 299 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна.

Хүснэгт 2. Авлигын гэмт хэргийн улмаас гарсан хохирол, тэрбум төгрөгөөр

Хохирлын төрөл	2016	2017	2018	2019
Учирсан хохирол-бүгд	38	70	663	12,123
Төрийн өмчид учирсан	32	63	657	12,123
Хувийн өмчид учирсан	1	3	3	-
Нөхөн төлүүлэлт	3	3	18	11

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn

2019 оны байдлаар авлигын гэмт хэргийн улмаас 12.1 их наяд төгрөгийн хохирол учирсан ба энэ нь өмнөх оноос бараг 20 дахин өссөн байна. Энэ нь Таван толгой, Оюу толгой гэх зэрэг уул уурхайн томоохон мега төслийн хэргүүдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасантай холбоотой ажээ. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан

хохирлын нөхөн төлөлтийн хэмжээ 2019 онд 11 тэрбум төгрөг байгаа нь нийт хохирлын 1 хүрэхгүй хувь болж байна. Цаашид авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд улсад учруулж буй хохирлыг бүрэн төлүүлэх, ял шийтгэлийг шударга оноох зэрэг хууль ёсны арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

График 8. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол, мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хөрөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: АТГ тайлан

2018 онд гэмт хэргийн улмаас 663.2 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 17.4 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлж үл хөдлөх,

хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 180.6 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжилжээ.¹⁰

График 9. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байдал



Эх сурвалж: АТГ тайлан

¹⁰ АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн шалгасан хэргийн тоо, 2019 оны 5 дугаар сарын 3.


График 10. Мөрдөн шалгасан хэргийн шийдвэрлэлт



Түүнчлэн 2018 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн тоо болон холбогдогчийн тоон мэдээллийг 2015 онтой харьцуулбал шалгагдсан этгээдийн тоо 2.6 дахин, хэргийн тоо 4.8 дахин өсжээ.

2018 оныг өмнөх онтой харьцуулахад мөрдөн шалгасан хэрэг 2.6 дахин, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 2 дахин, хэрэг бүртгэлийн хэрэг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг 4.9 дахин, үлдэгдэл хэрэг 1.9 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байх ба мөрдөн шалгасан хэргийн 72.4 хувийг хуулийн үндсэн хугацаанд шийдвэрлэсэн дүнтэй байна.

График 11. Шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын гэмт хэргийн тоо



Эх сурвалж: АТГ тайлан

Хүснэгт 3. Монгол Улсын анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл (2009–2016, 2017 оны эхний хагас жилийн байдлаар)¹¹

Он	Бүгд		Мөрдөн байцаалтад буцаасан		Үүнээс Хэргийг хэрэгсэхгүй болгосон			
	Хэрэг	Хүний тоо	Хэрэг	Хүний тоо	Хэрэг	Хүний тоо	Үүнээс: (ЭБШХ-ийн 25)	
							Хэрэг	Хүний тоо
2009	7	18	1	4	1	2	1	1
2010	11	27	5	14	2	2	0	0
2011	7	18	1	4	1	2	1	1
2012	11	27	5	14	2	2	0	0
2013	7	18	1	4	1	2	1	1
2014	11	27	5	14	2	2	0	0
2015	10	26	3	7	0	1	0	0
2016	8	15	4	9	1	1	0	0
2017	10	21	7	12	0	0	0	0
Нийт	82	197	32	82	10	14	3	3

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

¹¹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Монгол Улсын анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл”, 2017 он.

Хэдийгээр 2018 онд АТГ-аас шүүхэд шилжүүлэх саналтай 224 хэрэг байсан ч 34 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн бол, 2019 онд 156 хэргийг шүүхэд шилжүүлснээс 50 хэрэг шийдвэрлэгджээ.

Доорх дүн шинжилгээг авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх Шүүхийн

ерөнхий зөвлөлийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийлээ. Дээрх хүснэгтээс харахад 2009-2016, 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийтдээ 82 хэргийг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд нийт 197 хүн холбогджээ. Дээрх 82 хэргээс 10 хэрэг буюу 12 орчим хувийг хэрэгсэхгүй болгосон байна.

Хүснэгт 4. Монгол Улсын анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн мэдээлэл (2009–2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар)


Он	Бүгд		Үүнээс					Ял шийтгүүлсэн бүгд хүн
	Хэрэг	Хүн	Шийдвэрлэсэн нийт хэрэг	Цагаатгасан хэрэг	Цагаатгагдсан этгээд	Тайлангийн эцсийн үлдэгдэл		
						Хэрэг	Хүн	
2009	7	18	6	2	5	0	0	7
2010	11	27	10	1	1	2	2	0
2011	7	18	6	2	5	0	0	7
2012	11	27	10	1	1	2	2	0
2013	7	18	6	2	5	0	0	7
2014	11	27	10	1	1	2	2	0
2015	10	26	5	0	0	2	10	8
2016	8	15	4	1	1	0	0	4
2017	10	21	1	0	0	2	6	3
Нийт	82	197	58	10	19	10	22	36

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

Дээрх хүснэгтээс харахад, 2009 оноос 2017 оны эхний хагас жилд нийт 58 авлигын гэмт хэргийг анхан шатны шүүхээр

шийдвэрлэсэнээс 17 хувь буюу 10 гэмт хэрэгт холбогдсон 19 хүнийг цагаатгасан бол 36 хүнийг ял шийтгэсэн байна.

График 12. 2017–2019, 2020 оны нэгдүгээр сар хүртэлх авлигын хэрэг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүх (аймаг, нийслэлээр)



Мониторингийн явцад Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд буй Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл ангиар шийдвэрлэсэн хэргийг 2017-2019, 2020 оны нэгдүгээр сар хүртэлх хугацаагаар шүүж мэдээллийн сан үүсгэсэн болно. Тухайн хугацаанд нийт 83 авлигатай холбоотой эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоол байсан бөгөөд нийт 181 хүн холбогджээ. Үүнээс 60.2 хувь буюу

50 авлигын гэмт хэрэг 2019 онд шүүхээр шийдвэрлэгджээ. Эдгээр 83 гэмт хэргийн 55.0 хувь буюу 46 нь Улаанбаатар хотод шийдвэрлэгджээ.

Шүүхээр шийдэгдсэн авлигын гэмт хэргийн 66.0 хувь буюу ойролцоогоор 3 хэрэг тутмын 2 нь хээл хахууль авсан хэрэг байна. Харин эрх мэдлээ урвуулан ашигласан тохиолдол 24.0 хувийг эзэлжээ.


График 13. 2017–2019, 2020 оны нэгдүгээр сар хүртэлх анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг (Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрөл)



Хахууль авсан гэмт хэрэг нь Улаанбаатар хотод түлхүү үйлдэгдэж байгаа бол орон

нутагт эрх мэдлээ урвуулан ашиглах төрлийн гэмт хэрэг илүү үйлдэгдсэн байна.

График 14. 2017–2019, 2020 оны нэгдүгээр сар хүртэлх анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн гэмт хэрэг (нутаг дэвсгэрээр)



Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоор нийт гэмт хэргийн 91.5 хувьд ял оногдуулсан бол 8.5 хувийг хэрэгсэхгүй болгожээ. Албан тушаалаа урвуулан


ашигласан, авлигын гэмт хэрэгтэй холбоотой нийт 83 хэрэг анхан шатны шүүхээр орж 168 шүүгдэгчид холбогдсон шүүхийн шийдвэр гарчээ.

График 15. Анхан шатны шүүхээс авлигын гэмт хэрэгт оногдуулсан ял шийтгэл



Бусад хавсарсан ял шийтгэлийг тооцохгүйгээр торгуулийн ял авсан 89 шүүгдэгчийн 23 буюу 25.8 хувь нь дунджаар 2.7 сая төгрөгийг торгууль төлжээ. Шүүхээр шийтгүүлсэн нийт албан тушаалтны 86.5 хувь нь 10 хүртэлх сая төгрөгийн торгууль төлсөн бол 11.2 хувь нь 12-40 хүртэлх сая төгрөгийн торгууль, 2.3 хувь нь 100 сая болон түүнээс дээш төгрөгийн торгууль төлжээ.

График 16. Анхан шатны шүүхээр хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх




Авлигын хэргээр шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн хавсарсан ял шийтгэлийг тооцохгүйгээр тэнсэх ял авсан 37 иргэн байгаа бол хорих ял шийтгүүлсэн 27 иргэн байлаа. Тэнсэн харгалзах ялын хугацааг задалж харвал 27 буюу 73 хувь нь 1 жил, 8 буюу 21.6 хувь нь 2 жил, 2 буюу 5.4 хувь нь 3 жилийн тэнсэн харгалзах ялаар тус тус шийтгүүлжээ.

2017-2019, 2020 оны нэгдүгээр сар хүртэлх хугацаанд авлигын шинжтэй 42 гэмт хэргийг давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэжээ. Уг хэргүүдийн 54.7 хувь буюу 23 нь Улаанбаатар хотод шийдвэрлэгдсэн бөгөөд холбогдсон хүмүүсийн дунд олны танил хүн байхгүй. Мөн нийт гэмт хэргийн 30 буюу 71.4 хувь нь хахууль авсан хэрэг байна. Эрүүгийн давж заалдах шүүхийн шатанд 33 хэргийн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, 4 хэргийг анхан шатны шүүхэд шилжүүлж, мөн 4 хэргийг прокурорт, 1 хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийджээ.

Хорих ялаар шийтгүүлсэн 27 шүүгдэгчийн дийлэнх буюу 33.3 хувь нь 2 жилийн ял авчээ. Хамгийн олон жил буюу 5 жилийн хорих ялыг 2 хүнд оноосон бол хамгийн бага буюу 1 жилийн хорих ялыг 6 хүнд оногдуулжээ.

График 17. Анхан шатны шүүхээр хорих ял шийтгүүлсэн шүүгдэгчийн тоо (жилээр)



Дээрх хугацаанд авлигын шинжтэй 16 гэмт хэрэг хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэнээс 12 нь Улаанбаатар хотод харьяалалтай байна. Хэргийн төрлийг авч үзэхэд эрх мэдлээ урвуулан ашигласан, хахууль авсан гэх төрлийн хэргүүд

байсан бөгөөд хэрэгт холбогдсон албан тушаалтнууд нь олны танил биш бөгөөд 53 холбогдогч тогтоогджээ. Хяналтын шатны шүүхэд 15 хэргийн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг анхан шатны шүүхэд буцаасан байна.

1.3. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх олон нийтийн төсөөлөл

Мониторингийн хүрээнд олон нийтийн авлигын гэмт хэргийн талаарх төсөөлөл, өнөөгийн нөхцөл байдал болон олон нийтэд мэдээлэгдсэн хэргийн шийдвэрлэлтийн

байдалд ямар санаа бодолтой байдгийг тодруулах асуулгын судалгааг 100 хүнийг хамруулан 2020 оны 4 дүгээр сарын 10-18-ны өдрүүдэд явууллаа.


Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын шинж

№	Ангилал	Үзүүлэлт	Давтамж	Хувь (%)
		Нийт	100	100
1	Хүйсээр	Эрэгтэй	48	48.0
		Эмэгтэй	52	52.0
		%		
2	Насны бүлгээр	18-25	31	31.0
		26-35	25	25.0
		36-45	21	21.0
		46-55	16	16.0
		56-аас дээш	7	7.0
3	Байршлаар	Улаанбаатар	52	52.0
		Орон нутаг	48	48.0
4	Боловсролын байдлаар	Бүрэн бус, бүрэн дунд	18	18.0
		Бакалавр	72	72.0
		Магистр болон түүнээс дээш	10	10.0
		Төрийн байгууллага	14	14.0
5	Хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр	Төрийн бус байгууллага	9	9.0
		Хувийн байгууллага	40	40.0
		Хувиараа хөдөлмөр эрхлэгч	22	22.0
		Оюутан, суралцагч	4	4.0
		Тэтгэвэр, групп	3	3.0
		Ажилгүй	8	8.0

Дээрх ерөнхий мэдээллээс бидний судалгааны түүвэрлэлт тархалт сайтай, төлөөлөх чадвартай байгааг дурдах нь зүйтэй. Судалгаанд оролцсон иргэдээс авлигын шинж чанартай гэмт хэргийн талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас авдаг болохыг тодруулахад 67.0 хувь нь

нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер гэх мэт), 48.0 хувь нь телевиз, радио, FM, 31.0 хувь нь мэдээ, мэдээллийн сайтууд, 26.0 хувь нь найз нөхөд, хамаатан садан, хамтран ажиллагсад, 13.0 хувь нь сонин сэтгүүлээс авдаг гэжээ.


График 18. Мэдээлэл хүлээн авдаг эх сурвалжууд



Иргэд авлигын холбоотой мэдээллийг нийгмийн сүлжээнээс хамгийн их авдаг гэсэн бол баримт бичгийн судалгаагаар авлигын шинж чанартай гэмт хэргийн

мэдээ мэдээллийн сайт, өдөр тутмын сонин, сэтгүүл дээр хамгийн их нийтлэгддэг гэсэн үр дүн гарсан.


График 19. Мэдээллийн хүртээмжтэй байдал



Нийт судалгаанд оролцогчдын 87.0 хувь авлигатай холбоотой мэдээллийг их, бага хэмжээгээр авдаг гэсэн бол 4.0 хувь огт авдаггүй буюу сонирхдоггүй гэжээ. Эндээс

авлигын хэргийн талаарх мэдээллийг олон нийт сонирхож, анхаарал хандуулж байдгийг харж болох юм.

График 20. Гэмт хэргийн тоог өмнөх жилүүдтэй харьцуулсан байдал



Авлигын гэмт хэрэг өмнөх жилүүдтэй харьцуулахад хэр байгааг тодруулахад 38.0 хувь нь хэвээрээ, 25.0 хувь нь өссөн, 32.0 хувь нь хэлж мэдэхгүй, 5.0 хувь нь буурсан

гэж хариулжээ. Мөн 10 хүн тутмын 3 нь өссөн, буурсан талаар хэлж мэдэхгүй байгаа нь энэ талаар мэдээлэл муу байгааг илтгэж байна.


График 21. Авлигын гэмт хэрэг аль шатанд хамгийн их байгаа байдал, хувиар



Судалгаанд оролцогчдын 52.0 хувь нь авлигын гэмт хэрэг бүх шатанд байна гэж үзсэн бол, 17.0 хувь УИХ-ын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнуудын дунд байна гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, 2 хүн тутмын 1 нь авлигын гэмт хэрэг бүх шатанд байдаг гэж боддог ажээ. АТГ-ын хийдэг шударга байдлын үнэлгээний судалгаанд шүүхийн


байгууллага тэргүүлсэн бол энэ асуулгын дүнд төрийн өндөр албан тушаалтан, шүүх, хуулийн байгууллагын албан тушаалтны холбогдсон хэргийн мэдээлэл давамгайлж байна. Эндээс дүгнэхэд УИХ-ын гишүүн, төрийн өндөр албан тушаалтны авлигын асуудалд олон нийт илүү анхаарал хандуулж байна гэж үзэж болохоор байна.

График 22. Хуулийн байгууллагууд хэргийг үнэн зөв шийдвэрлэдэг байдал, хувиар



Судалгаанд оролцогчдын хувьд цагдаа, байгаа бол АТГ-т арай их итгэл хүлээлгэдэг прокурор, шүүхэд итгэх итгэл хангалтгүй болох нь харагдаж байна.


График 23. Төрийн өндөр албан тушаал хашиж байсан болон олны танил хүмүүсийн оролцсон авлигын хэргийн шийдвэрлэлтийн байдал, хувиар



Төрийн өндөр албан тушаал хашиж байсан болон олны танил хүмүүсийн оролцсон авлигын хэргүүдийн шийдвэрлэлтийн талаар нийт судалгаанд оролцогчдын 38.0 хувь нь мэдээлэл нийтэд ил болдоггүй тул хэрхэн шийдвэрлэсэн талаар хэлж мэдэхгүй байна гэж үзжээ. Түүнчлэн 27.0 хувь нь үнэн зөв шийдвэрлэгддэггүй, танил талаараа хэргийг замхруулдаг, 18.0 хувь нь АТГ, цагдаагаас шалгахгүй хав дардаг, 12.0 хувь нь шүүх үнэн зөв шийддэггүй, шударга ял өгдөггүй, 4.0 хувь нь прокурорын шатанд хэргийг дардаг, хэрэгсэхгүй болгодог гэж хариулжээ.

Мониторингийн дүнгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдэж буй авлигатай холбоотой хэргийн ихэнх нь шийдвэрлэгдээгүй байсны зэрэгцээ шийдсэн хэргийн тухайд хөнгөн ял оногдуулж байгаа гэсэн дүн гарсан нь иргэдийн хувьд шүүх, хуулийн байгууллагад итгэхгүй байгаагийн хариулт байж болох юм. Судалгаанд хамрагдсан иргэдийн дөнгөж 1 хувь нь авлигын хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэдэг гэж хариулжээ.


График 24. Төрийн өндөр албан тушаал хашиж байсан болон олны танил хүмүүсийн оролцсон авлигын хэргийг гацаах байдал, хувиар



Төрийн өндөр албан тушаал хашиж байсан болон олны танил хүмүүсийн оролцсон авлигын хэргүүд хаана гацаж буйг тодруулахад нийт судалгаанд оролцогчдын

62.0 хувь нь бүх шатанд гэж хариулжээ. Энэ нь иргэд, олон нийт авлигын гэмт хэрэг бүх шатанд байгаа гэсэн хатуу үзэл бодолтой болсныг илтгэн харуулж байна.


График 25. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг үнэн зөв хүргэдэг эсэх, хувиар



Нийт судалгаанд оролцогчдын 46.0 хувь нь ихэнх мэдээлэл нуун дарагдаад олон нийтэд хүрдэггүй гэж үзсэн бол үнэн бодитой гэж ердөө 1.0 хувь нь л үзжээ. Иргэд, олон нийт хангалттай үнэн зөв мэдээлэл авч чаддаггүй, нөгөө талаар мэдээлэлд итгэх итгэл сул байгааг эндээс харж болохоор байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл иргэд

олон нийттэй хамтран авлигатай тэмцэх гол хөшүүрэг болох учиртай. Гэтэл иргэд олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж буй хэргүүдэд үл итгэсэн, бодит байдалд эргэлздэг байр суурьтай байгаа нь цаашид мэдээллийн бодлогод анхаарах шаардлагатайг илэрхийлсэн үзүүлэлт юм.

График 26. Олон нийтэд хүрч буй мэдээлэлд итгэх байдал



Аль байгууллага, мэдээллийн сувгийн олон нийтэд мэдээлж буй мэдээлэлд хамгийн их итгэдэг болохыг тодруулахад, нийт судалгаанд оролцогчдын 48.0 хувь нь телевиз, 41.0 хувь нь Засгийн газар, 37.0 хувь нь АТГ, 35.0 хувь өдөр тутмын сонин, 33.0 хувь нь цагдаа, 23.0 хувь нь мэдээ, мэдээллийн сайт, 23.0 хувь нь шүүх, 14.0

хувь нь прокурор, 13.0 хувь нь нийгмийн сүлжээний мэдээлэл, 13.0 хувь нь улс төрчдийн хийсэн мэдээлэлд гэж хариулжээ. Иргэд, олон нийт одоогийн байдлаар мэдээллийг нийгмийн сүлжээнээс авдаг боловч тэрхүү мэдээлэлдээ хэт их итгэдэггүй болохыг эндээс харж болохоор байна.

График 27. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн олон нийтэд хүрч буй байдал, хувиар



Нийт судалгаанд оролцогчдын 37.0 хувь авлигын гэмт хэрэг хэрхэн шийдвэрлэгдсэн нь олон нийтэд хүрдэггүй гэж үзсэн бол, 20.0 хувь нь огт хүрдэггүй хэмээжээ. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн

олны анхааралд орсон хэргүүдийн хувьд эцэслэн шийдвэрлэж буй байдал удаашралтай, хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхой бус байсантай холбоотой.

График 28. Авлигын гэмт хэргийн мэдээллийг хүлээн авах ач холбогдол, хувиар



Авлигын шинж чанартай гэмт хэргийн мэдээллийг хүлээн авах нь нийт судалгаанд оролцогчдын 23.0 хувьд маш чухал ач холбогдолтой, 30.0 хувьд чухал ач холбогдолтой, 17.0 хувьд дунд зэрэг ач холбогдолтой байгаа нь авлигатай холбоотой мэдээллийг хүлээн авах нь иргэд, олон нийтэд их бага ямар нэгэн хэмжээгээр

ач холбогдолтойг харуулжээ. Энэ нь авлигыг таслан зогсоох, авлигатай тэмцэх хүсэл сонирхол иргэдэд өндөр байдгийг харуулж байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 79.0 хувь нь авлигын гэмт хэргийг олон нийтэд мэдээлэх нь тухайн гэмт хэргийг бууруулах нэг хөшүүрэг болж чадна гэж үзжээ.

График 29. Цаашид хэвлэл мэдээллийн байгууллагын хүргэх мэдээлэл, хувиар



Цаашид хэвлэл мэдээллийн байгууллага авлигын хэргийг хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх мэдээллийг хүргэх нь зүйтэй гэж 31.0 хувь үзсэн бол, 29.0 хувь нь хэргийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл, 23.0 хувь нь эрэн сурвалжлах чиглэлийн мэдээлэл, 17.0 хувь нь урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл хүргэх нь зүйтэй гэж үзжээ. Иргэд илүүтэй авлигыг илрүүлэхийн

хамт шийдвэрлэлтийн байдалд анхаарал хандуулах нь зүйтэй гэсэн байр суурьтай байлаа.

Иргэдээс олон нийтийн анхаарлын төвд байгаа ямар хэрэг шударга бус шийдэгдсэн эсвэл хаагдсан, замхарсан гэж боддог талаарх асуултын хариуг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 6. Иргэдийн хаагдсан, замхарсан гэж боддог хэргийн талаарх сэтгэгдэл

1	60 тэрбумын хэрэг дээр 3 оролцогчоос М.Энхболдыг үлдээж, нөгөө 2 залууд ял өгсөн нь шударга бус М.Энхболдыг илт хаацалсан шийдвэр гэж үзэж байна.
2	Баярцогт, Сайханбилэг нарын Оюу толгойн гэрээ, Зоригийн хэрэг, ЖДҮ-ийн хэрэг, Оффшор, 60 тэрбумын хэрэг
3	Нийгэмд болоод байгаа ЖДҮ-ээс эхлээд хурган дарга нарын авлигын асуудал тэгсхийгээд алга болдог. Ер нь бол авлигын асуудал Монголд шийдэгддэг гэдэгт итгэлгүй байна. Учир нь бүх шат нь авлигажсан учраас ихэнх нь замхардаг.
4	Ноён уул, говийн байгаль хамгаалагч залуу
5	Оймсондоо мөнгөө хийсэн хүн
6	Олон нийтэд цацагдаж шуугиан тарьж байсан бүх хэргүүд шийдвэрлэх шатан дээрээ очоод явц нь удааширч замхардаг гэж бодож байна.
7	Өмнөговь аймгийн дарга нарын асуудал, Таван толгой ХК гэх мэт ЖДҮ авахдаа өгсөн авлига.

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд 60 тэрбумын хэргийн шийдвэрлэлтийн байдал болон Оюутолгойн ордын гэрээтэй холбоотой асуудалд шүүмжлэлтэй хандаж байлаа. Олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүрч буй мэдээллийн хүрээнд ойлголт мэдээлэл авч байна. Авлигын тухай олон нийтэд хүрч буй мэдээллийн агуулга нь албан тушаалтны гэмт хэрэгт холбогдсон талаарх мэдээлэл, шалгагдаж байгаа тухай мэдээллээр хязгаарлагдаж, хэрхэн шийдвэрлэсэн, шалгалтын үйл ажиллагаа аль шатандаа явж байгаа талаарх мэдээлэл хүрэхгүй байгааг мониторингийн үр дүн болон дээрх судалгааны дүнгээс харагдаж

байна. Олон нийтэд хүрч буй ихэнх хэрэг төрийн өндөр албан тушаал хашиж байсан улс төрчидтэй холбогдсон хэргүүд байгаа ба хэргийн шийдвэрлэлт олон жил, сараар үргэлжилж сүүлдээ мэдээлэх байдал муудаж байгаа нь иргэдэд хэрэг замхарч байгаа сэтгэгдэл төрүүлж байна. Түүнчлэн шүүх, хууль хяналтын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг сулруулж байна гэж үзэж болох юм. Иймд олон нийтэд хүрсэн авлигын хэргээс гадна шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын хэргийн шийдвэрлэлтийн байдлыг олон нийтэд нээлттэй ил тод мэдээлж байх нь авлигатай тэмцэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Манай улсад авлигын шинж чанартай гэмт хэрэг буурахгүй байгаа нь жил тутамд хийдэг судалгаануудын дүнгээс тодхон харагдаж байна. Авлигын гэмт хэрэг нийгмийн бүх шатанд төрийн удирдах дээд байгууллагаас эхлэн сум баг, байгууллагын түвшинд хүртэл

бат шингэн оршсоор байгаа нь олон нийтийн дургүйцлийг хүргэж байна.

2019 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 162.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан бол авлигын гэмт хэргийн улмаас 12.1 их наяд төгрөгийн хохирол

учирсан талаар ҮСХ, АТГ-ын тайланд дурдагджээ. Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос 74 дахин их үзүүлэлт юм. Хохирлын дүн мэдээний зөрүүнээс харахад авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын дүнг мэдээнд оруулаагүй байна.

Авлигын гэмт хэргүүд шүүхээр хянан шийдвэрлэгддэг хэдий ч хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ талаар хангалттай мэдээлэгддэггүй ажээ. Тухайлбал, 2007 оноос 2020 оны 1-р улирлыг дуустал хугацаанд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхээр нийтдээ 165 авлигатай холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн ч эдгээр хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажил огт хийгдээгүй гэж болохоор байна. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн хэргүүд нь АТГ хэвлэлийн хурлаар мэдээлсэн олны танил буюу өндөр албан тушаал хашиж байсан хүнтэй холбоотой хэргийн талаар түлхүү мэдээлжээ. Дээрх олон нийтийн анхаарлын төвд орсон томоохон хэргүүд анх зарлагдаад олон нийтэд мэдээлснээс хойш шалгагдаж байгаа нэрээр шүүхэд шилжиж, дийлэнх нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Дээрх шалтгааны улмаас шүүх, хуулийн байгууллага, түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх иргэдийн итгэл буурчээ. Иймд том, бага гэлтгүй авлигын хэргээр шийдвэрлэгдэж буй бүх хэргийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх нь илүү үр дүнтэй юм.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоор нийт гэмт хэргийн 91.5 хувьд ял оногдуулсан бол 8.5 хувийг хэрэгсэхгүй болгожээ. Анхан шатны шүүхээр 168 шүүгдэгчийн 37 шүүгдэгчид тэнсэх ял, 27 шүүгдэгчид хорих ял оногдуулжээ. Хорих ялаар шийтгүүлсэн 27 шүүгдэгчийн дийлэнх буюу 33.3 хувь нь 2 жилийн ял авчээ. Бусад хавсарсан ял шийтгэлийг тооцохгүйгээр торгуулийн ял авсан 89 шүүгдэгчийн 86.5 хувь нь 10 хүртэлх сая төгрөгийн торгууль төлжээ.

Иргэд, олон нийт авлигын гэмт хэрэг бүх шатанд байгаа гэж үзэхийн зэрэгцээ, тухайн гэмт хэргийн шийдвэрлэлтийг гацаах байдал ч мөн бүх шатанд байна гэж үздэг ажээ. Түүнчлэн уг гэмт хэргийг мөрдөх, шийдвэрлэх шатанд ажилладаг хууль, хяналтын байгууллагыг үнэн зөв шийдвэрлэдэггүй, аль нэг шатанд хав дардаг гэх хардлага иргэдийн дунд байсаар байна. Нийт судалгаанд оролцогчдын 46.0 хувь нь ихэнх мэдээлэл нуун дарагдаад олон нийтэд хүрдэггүй гэж үзсэн бол үнэн бодитой мэдээлэл хүрдэг гэж ердөө 1.0 хувь нь л үзжээ.

Авлигын гэмт хэргийн мэдээллийг хүлээн авах нь иргэд, олон нийтэд их бага ямар нэгэн хэмжээгээр ач холбогдолтой байгаа бөгөөд энэ нь тухайн төрлийн гэмт хэргийг буруулах нэг хөшүүрэг болж чадна гэдэгт итгэлтэй байна. Цаашид хэвлэл мэдээллийн байгууллага авлигын хэргийг хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх мэдээллийг хүргэх нь зүйтэй гэж 31.0 хувь үзсэн бол 29.0 хувь нь хэргийн шалгалтын явц, үр дүнгийн талаар, 23.0 хувь нь эрэн сурвалжлах чиглэлийн, 17.0 хувь нь урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл хүргэх нь зүйтэй гэж байлаа.

Нийгмийг авлигаас ангижруулах, авлига хэмээх нийгмийн хорт хавдартай бүх нийтээр тэмцэж байж бодит үр дүнд хүрэх билээ. Тиймээс зөвхөн хууль хяналтын байгууллага бус хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо чухал бөгөөд авлигын талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас өгсөн мэдээллээр хязгаарлах бус, эрэн сурвалжлах, шийдвэрлэлтийн байдалд анализ, дүгнэлт хийж мэдээлэх талд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Авлигын нөхцөл байдлын талаар ил тод байх мэдээлэл, судалгаа хангалтгүй, тоон үзүүлэлт нь цаг хугацаа, тайлан гаргах онцлогоос зөрдөг зэргээс шалтгаалан олон нийт бодитой мэдээлэл авах боломж хязгаарлагдаж байна. Түүнчлэн Авлигын

¹² Зарим авлигын гэмт хэрэг нь эдийн засгийн болон залилан мэхлэх гэмт хэрэг болон шалгагдах тохиолдол байдаг.

эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.17-д зааснаар авлигын индекс, төрийн байгууллагын шударга байдлын түвшнийг судалж олон нийтэд мэдээлэх АТГ-ын үндсэн чиг үүргийг “Шударга байдлын үнэлгээ” гэх ерөнхий байдлаар гаргасан нь учир дутагдалтай.

Олон нийт төдийгүй судалгаа шинжилгээний байгууллага, судлаачдад хуулиар хориглоогүй, ил тод байх ёстой мэдээллийг

олжавахад түвэгтэй байсныг дурдах нь зүйтэй. Тиймээс авлигатай холбоотой мэдээллийг нээлттэй олж авах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний тулд авлигын гэмт хэргийн талаарх Шүүх, Прокурор, АТГ, Цагдаагийн¹² байгууллагын болон Өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн байгууллагын мэдээллийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ

- Авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг олны танил, улстөрийн өндөр албан тушаалтны хүрээнд хязгаарлахгүйгээр нийтэд мэдээлэх;
- Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын дүнд тусгаж байх;
- Авлигын хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгах;
- Бүх шатны тендер, худалдан авах үйл ажиллагаа, газар олголт гэх мэт асуудлаар эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжих, тэдгээрийн мөрөөр хууль, хууль сахиулах байгууллага тодорхой ажил зохион байгуулдаг байх;
- Авлигын хэргийн шийдвэрлэлтийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран тухай бүр хүргэж хэвших;
- Шүүх, прокурор болон АТГ хамтран авлигын гэмт хэргийн нөхцөл байдал, илрүүлэлт, шалгалтын үйл ажиллагаа, хэргийн шийдвэрлэлтийн талаар телевизийн цуврал нэвтрүүлэг хийж олон нийтэд хүргэж хэвших;
- Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.17-д зааснаар авлигын индекс, төрийн байгууллагын шударга байдлын түвшнийг судалж олон нийтэд мэдээлэх АТГ-ын чиг үүргийг хөндлөнгийн хараат бус байгууллагаар хийлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Авлигын гэмт хэргийн талаарх Шүүх, Прокурор, АТГ, Цагдаагийн байгууллагын болон Өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн байгууллагын нэгдсэн статистик тогтолцоог боловсронгуй болгох.

МОНИТОРИНГ ХИЙСЭН СУДЛААЧИД:

Л.Буддорж, Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Г.Эрдэнэ, Эдийн засагч статистикч, МВА, Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв ТББ-ын зөвлөх

Э.Должин, Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв ТББ-ын зөвлөх судлаач
Б.Батзориг, Хууль зүйн ухааны доктор Ph.D, Монголын Криминологичдын холбооны УЗ-ийн дарга

МОНИТОРЫГ ЭМХЭТГЭЖ БИЧСЭН:

ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14240

Утас: (976) 76113207
И-мэйл: osf@forum.mn,
Вэб: www.forum.mn